

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-/325/2023-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2022
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.10 № 01/38
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН
ДАРГА Д.БАТЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Авлага дансны эхний үлдэгдэл 1,037,790.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,397,575.0 мянган төгрөг болж 359,784.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн эргэн төлөгдөх хугацаатай холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,037,790,142	1,397,575,053
33	АВЛАГА	1,037,790,142	1,397,575,053
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,371,000	-
335	Бусад авлага	1,035,419,142	1,397,575,053
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,035,419,142	1,397,575,053
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,037,790,142	1,397,575,053
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,037,790,142	1,397,575,053
51	Засгийн газрын хувь оролцоо	1,037,790,142	1,397,575,053
512	Хуримтлагдсан үр дүн	1,037,790,142	1,397,575,053
51210	Өмнөх үеийн үр дүн	1,037,790,142	1,037,790,142
51220	Тайлант үеийн үр дүн	-	359,784,911
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,037,790,142	1,397,575,053

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	883,850,669.11	1,914,159,784
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	140,997,119.11	164,209,784
120	Нийтлэг татварын бус орлого	140,997,119.11	164,209,784
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	140,997,119.11	164,209,784
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,997,119.11	164,209,784
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	742,853,550.00	1,749,950,000
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	742,853,550.00	1,749,950,000
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,010,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	734,843,550.00	1,749,950,000
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,176,308,528.11	1,554,374,873
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,176,308,528.11	1,554,374,873
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,738,356.00	4,415,500
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,450,356.00	4,415,500
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,450,356.00	4,415,500
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	288,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	288,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,171,570,172.11	1,549,959,373
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	301,400,513.11	711,001,134
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	140,997,119.11	164,209,784
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,722,000.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,722,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	669,957,859.00	530,715,089
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	669,957,859.00	530,715,089
2132	Бусад урсгал, шилжүүлэг	192,489,800.00	308,243,150
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	192,489,800.00	308,243,150
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(292,457,859.00)	359,784,911
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(292,457,859.00)	359,784,911

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	883,850,669.11	1,914,159,784
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	140,997,119.11	164,209,784
120	Нийтлэг татварын бус орлого	140,997,119.11	164,209,784
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	140,997,119.11	164,209,784
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,997,119.11	164,209,784
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	742,853,550.00	1,749,950,000
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	742,853,550.00	1,749,950,000
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,010,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	734,843,550.00	1,749,950,000
14	Үйл ажиллагааны бус орлого	672,328,859.00	530,715,089
145	Бусад орлого	672,328,859.00	530,715,089
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,556,179,528.11	2,444,874,873
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,556,179,528.11	2,444,874,873
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,738,356.00	4,495,500
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,450,356.00	4,495,500
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,450,356.00	4,495,500
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	288,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	288,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,551,441,172.11	2,440,379,373
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	301,400,513.11	711,001,134
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	140,997,119.11	164,209,784
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	160,403,394.00	546,791,350
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,722,000.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,722,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	672,328,859.00	530,715,089
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	672,328,859.00	530,715,089
2132	Бусад урсгал шилжүүлэг	569,989,800.00	1,198,663,150
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	569,989,800.00	1,198,663,150
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(672,328,859.00)	530,715,089
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
14	Бусад эх үүсвэр	672,328,859.00	530,715,089
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	672,328,859.00	530,715,089
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	672,328,859.00	530,715,089
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,037,790,142.00	0.00	1,037,790,142.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,037,790,142.00	0.00	1,037,790,142.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,037,790,142.00	0.00	1,037,790,142.00
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,037,790,142.00	0.00	1,037,790,142.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,037,790,142.00	0.00	1,037,790,142.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	359,784,911.00	0.00	359,784,911.00
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,397,575,053.00	0.00	1,397,575,053.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
72102	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	1,749,950,000.0	1,203,158,650.0	68.8
80224	Зөвлөл хороо гишүүдийн ажлын хөлс	4,500,000.0	4,495,500.0	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,500,000.0	4,495,500.0	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,500,000.0	4,495,500.0	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,500,000.0	4,495,500.0	99.9
82602	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих	161,791,000.0	134,583,000.0	83.2
2	Урсгал зардал	161,791,000.0	134,583,000.0	83.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	161,791,000.0	134,583,000.0	83.2
82604	Аж ахуй эрхлэлтийг дэмжих	910,557,000.0	622,323,000.0	68.3
2	Урсгал зардал	910,557,000.0	622,323,000.0	68.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	910,557,000.0	622,323,000.0	68.3
82606	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт	51,246,000.0	22,800,000.0	44.5
2	Урсгал зардал	51,246,000.0	22,800,000.0	44.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,246,000.0	22,800,000.0	44.5
82609	Ахмад мэргэжилтэний хөдөлмөр эрхлэлт	253,200,000.0	230,580,000.0	91.1
2	Урсгал зардал	253,200,000.0	230,580,000.0	91.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	253,200,000.0	230,580,000.0	91.1
82612	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох	11,100,000.0	9,272,000.0	83.5
2	Урсгал зардал	11,100,000.0	9,270,000.0	83.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,100,000.0	9,270,000.0	83.5
82613	Ажилд зуучлах	4,200,000.0	3,254,640.0	77.5
2	Урсгал зардал	4,200,000.0	3,254,640.0	77.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,200,000.0	3,254,640.0	77.5
82616	ЗГ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	323,216,000.0	170,420,510.0	52.7
2	Урсгал зардал	323,216,000.0	170,420,510.0	52.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	323,216,000.0	170,420,510.0	52.7
82618	Хөдөлмөрт бэлтгэх	30,140,000.0	5,430,000.0	18.0
2	Урсгал зардал	30,140,000.0	5,430,000.0	18.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,140,000.0	5,430,000.0	18.0
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,724,310,000.0	1,203,158,650.0	69.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,749,950,000.0	1,203,158,650.0	68.8
1311	Улсын төсвөөс санхүүжих	1,749,950,000.0	1,203,158,650.0	68.8
12000	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ			

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	694,924,873.00
12	Татварын бус орлого	164,209,784.00
120	Нийтлэг татварын бус орлого	164,209,784.00
120010	Төсөвт байгууллагын өөрийн орлого	164,209,784.00
32	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	530,715,089.00
32	Төслийн зээл	530,715,089.00
321102	Үндсэн төлбөр	530,715,089.00
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мэргэжилтэн, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн, хөдөлмөрийн зах зээл дэх ажлын байрны шилжилт хөдөлгөөн ажил зуучлал хариуцсан мэргэжилтэн, ажил мэргэжлийн чиг баримжаа хариуцсан мэргэжилтэн гэсэн 5 орон тоогоор үйл ажиллагаа явуулсан байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлж ажилласан байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилгоор иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх зорилт тавин ажиллажээ.

Тус газар нь тайлант онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний талаар тусгагдсан зорилт арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэн 92,3 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Нийгмийн халамжийн тухай хуулийн зарим заалтуудад 2022 оны 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн зарим заалтуудад 2022 оны 04 дүгээр сарын 22-нд нэмэлт өөрчлөлт орсон гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн "Дотоод хяналтын нэгж томилох тухай" А/65 тушаалаар шинэчлэн томилж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын даргын 2020 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн А/158 тоот тушаалаар "Дотоод хяналт зохион байгуулалтын журам" боловсруулан баталж мөрдөн ажилласан байна.

Тус байгууллагын дотоод хяналтын нэгж нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрүүдийн эргэн төлөлт, үр дүнд хяналт тавих зорилгоор дотоод хяналт хийх календарьчилсан төлөвлөгөөг боловсруулан ажилласан байна.

Төв аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь 2019-2021 онд Залуучууд хүүхэд эмэгтэйчүүдийг дэмжих хөтөлбөр, ажлын байрыг дэмжих хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд хамрагдсан 12 сумын 57 иргэдийн төслийн үйл ажиллагаа болон зээлийн эргэн төлөлтөд хяналт шалгалтыг хийж ажилласны үр дүнд хөдөлмөр эрхлэлтийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 94,1%-ийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Тус байгууллагын дотоод хяналтын нэгж нь сумын хөдөлмөр хариуцсан мэргэжилтэн нарт зөрчил дутагдлыг дахин гаргахгүй байх, ажилдаа хариуцлагатай хандах, төлөвлөгдсөн ажлуудын хэрэгжилтэд анхаарах чиглэлээр 5 удаа цахим болон цаасан хэлбэрээр арга зүйн чиглэл, зөвлөмж өгч ажилласан байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн 2022 оны ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн №А/289 тоот тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс мөрдөж эхэлсэн байна. Энэхүү баримт бичигт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бүртгэл тайлагналын бүртгэлийн үйл ажиллагааг 4 бүлэгт тусгасан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 359,784.9 мянган төгрөгөөр буюу 34,66 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	
Авлага	1,037,790.1	1,397,575.0	-359,784.9
Бараа материал	0	0	
Үндсэн хөрөнгө	0	0	
Нийт хөрөнгө	1,037,790.1	1,397,575.0	-359,784.9
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/			
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,037,790.1	1,397,575.0	-359,784.9

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд авлага дансны эхний үлдэгдэл 1,037,790.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,397,575.0 мянган төгрөг болж 359,784.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн эргэн төлөгдөх хугацаатай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,317,291.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 2022 онд хэрэгжих хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн зардлыг 16,640.0 мянган төгрөг, ногоон ажлын байр хөтөлбөр 200,000.0 мянган төгрөг, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн зардлыг 216,018.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, 1,749,950.0 мянган төгрөгөөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг 60,000.0 мянган төгрөгөөр нийт 1,809,950.0 мянган төгрөгийг батлан ирүүлсэн байна. Энэ нь 2022 онд шинээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний зардал 432,658.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,749,950.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 60,000.0 мянган төгрөгийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,749,950.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогоос 164,209.8 мянган төгрөг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөөс 530,715.1 мянган төгрөгийг бүрдүүлж, төсөвт 546,791.4 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,203,158.6 мянган төгрөг буюу 68.8 хувьтай байгаа нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардлын төсвийг 152,795.5 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 27,208.0 мянган төгрөг, аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр 288,234.0 мянган төгрөг, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 28,446.0 мянган төгрөг, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 22,620.0 мянган төгрөг, хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр 24,710.0 мянган төгрөг, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ хөтөлбөр 2,777.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	72102-80224	4,500.0	4,495.5	4.5	99.9
2	72102-82602	161,791.0	134,583.0	27,208.0	83.2
3	72102-82604	910,557.0	622,323.0	288,234.0	68.3
4	72102-82606	51,246.0	22,800.0	28,446.0	44.5
5	72102-82609	253,200.0	230,580.0	22,620.0	91.1
6	72102-82612	11,100.0	9,272.0	1,828.0	83.5
7	72102-82613	4,200.0	3,254.6	945.4	77.5
8	72102-82616	323,216.0	170,420.5	152,795.5	52.7
9	72102-82618	30,140.0	5,430.0	24,710.0	18.0
	Дүн	1,749,950.0	1,203,158.6	546,791.4	68.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нэмэлт санхүүжилтийн дансанд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлого 164,209.7 мянган төгрөг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 530,715.1 мянган төгрөг нийт 694,924.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 694,924.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	72102	2022.01.01 2022.12.31	Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилгоор иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт 92,3%	1,749,950.0	1,203,158.6

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн хөдөлмөр эрхлэлтийн зээлийн хугацаа хэтэрсэн эргэн төлөлтийн авлагыг бууруулах, шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 25 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамнаас баталсан 2022 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамнаас баталсан 2022 оны төсвийг, суурь үзүүлэлтийг 2022 оны батлагдсан төсвийн 1,809,950.0 мянган төгрөгийн нийт зардлаас 1,0 хувиар буюу 18,099.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 12,669.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага 6 хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө гарган 359 иргэнтэй холбоотой 528,344.1 мянган төгрөгийг төвлөрүүлж, үүнээс 317,432.0 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 92,5%-тай, 5,0 саяас дээших орлогын 30 гүйлгээ, зарлагын 171 гүйлгээ, үүнээс 15 орлогын гүйлгээ хугацаа хоцроож мэдээлсэн, 5,0 саяас дээших худалдан авалттай холбоотой 59 гүйлгээ, үүнээс 3 гүйлгээ хугацаа хоцроож байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлттэй холбоотой 2 албан шаардлага өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын даргын 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 221 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	23,287.7	2	23,287.7	100
Зөвлөмж					
Нийт дүн	2	23,287.7	2	23,287.7	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 221,441.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 2,371.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 219,070.9 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 2,371.0 мянган төгрөгийн алдаа² илэрснээс аудитын явцад 2,371.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1.Тус байгууллага тайлант онд мөнгөн гүйлгээний тайлангийн нийт мөнгөн орлогын дүн 2,371.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар 219,070.9 мянган төгрөгийн зөрчил³ илэрснээс, 219,070.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 2018-2022 онуудад хэрэгжиж байгаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 6 хөтөлбөрт олгосон эргэн төлөгдөх зээлээс 75 иргэний 127,202.9 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

2. Тус байгууллага тайлант онд шилэн дансанд зарлагын 75,000.0 мянган төгрөгийн 15 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 16,868.0 мянган төгрөгийн 3 тушаал шийдвэрийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж:Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
							Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайлангийн нийт мөнгөн орлогын дүн зөрүүтэй тайлагнасан.	1	2,371.0			1	2,371.0	1	2,371.0
Дүн	1	2,371.0			1	2,371.0	1	2,371.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 2018-2022 онуудад хэрэгжиж байгаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 6 хөтөлбөрт олгосон эргэн төлөгдөх зээлээс 75 иргэний хугацаа хэтэрсэн зээл байна	1	127,202.9					1	127,202.9
Дүн	1	127,202.9					1	127,202.9

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс	
			Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил				
Шилэн дансанд зарлагын 75,000.0 мянган төгрөгийн 15 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 16,868.0 мянган төгрөгийн 3 тушаал шийдвэрийг хугацаа хоцроож байршуулсан.	1	91,868.0	1	91,868.0
Дүн	1	91,868.0	1	91,868.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил				
Дүн				
Нийт дүн	1	91,868.0	1	91,868.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn